



**"ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ
УДИРДЛАГЫН ТӨВ" ОНӨТҮГ**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
Бага тойруу 15 дугаар гудамж, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0056
Утас: (976) 7011 1642, (976-51) 26 07 70
Цахим шуудан: info@ubtraffic.mn
Цахим хуудас: www.ubtraffic.mn

2024.08.26 № 01/736

танай _____-ны № _____-т

Тодруулга гаргах тухай

“Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-ээр “Гэрлэн дохио болон гадна талбайн бусад тоног төхөөрөмжүүдийн цахилгаан, тэжээл, худаг сувагчлал” хийх ажлын тендерийг 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр зарлаж 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 10 минутад нээхээр зарласан боловч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/ 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөр бүртгэн авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь заалт “нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш байх” гэх заалтыг зөрсөн байх тул тендер хүлээн авах хугацааг хуульд нийцүүлэн 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 10 минут хүртэл хугацаагаар сунгаж өгч бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.



Замын хөдөлгөөний удирдлагын төв
Удирдлага
Захирал
Чулуунхүү ХУВЬЗАЯА
2024.08.26 17:42

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| | |
|-------------------------------|---|
| ТШЗ-ны холбогдох заалт | А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ |
| ТШЗ 1.1 | Захиалагч: Нийслэлийн Замын Хөгжлийн газар |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын нэр: Гэрлэн дохио болон гадна талбайн бусад тоног төхөөрөмжүүдийн цахилгаан, тэжээл, худаг сувагчлал |
| ТШЗ 1.1 | Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: НХААГ/20240101287 |
| ТШЗ 1.2 | Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Багцгүй” |
| ТШЗ 1.3 | Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй” |
| ТШЗ 2.1 | Санхүүжилтийн эх үүсвэр нь: Орон нутгийн замын сан |
| ТШЗ 2.1 | Нийт төсөвт өртөг: 170,000,000 (Нэг зуун далан сая) төгрөг |
| Б. АГУУЛГА | |
| ТШЗ 9.1 | Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: Санхүү төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Л.Мөнхжаргал Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 15, Нийслэлийн засаг захиргааны 4-р байр 7 давхар 705 тоот. Утасны дугаар: 70111628 Цахим шуудан: jagai.mg@gmail.com |
| ТШЗ 10.1 | Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: эсхүл “Үгүй” |
| В. ТЕНДЕР БЭЛТГЭХ | |
| ТШЗ 12.1 | Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл. |
| ТШЗ 15.1 | Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй” |
| ТШЗ 16.1.2 | Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана.” <ul style="list-style-type: none">- Тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системээс авсан нийгмийн даатгалын шимтгэлийн болон татварын өр төлбөргүй тодорхойлолтыг цахим системийн холбогдох талбараар зааварчилгааны дагуу тус тус ирүүлнэ. Энэхүү тодорхойлолтыг ирүүлээгүй тохиолдолд тендер нээсэн өдрийн байдлаар татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өр төлбөрийн талаарх мэдээллийг шалгана.- Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр, төлбөргүй талаархи хүчин төгөлдөр лавлагааг цахим системээс авч, |

| | |
|------------------------|---|
| | <p>зааварчилгааны дагуу цахим системээр холбогдох талбараар ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын шимтгэлийг 2023 оны 11, 12 дугаар сар, 2024 оны 01 дүгээр сарын тендерт оролцогч тасралтгүй төлсөн болохыг нотлох НД-7, НД8 маягтаар гаргасан тайланг ирүүлнэ. - Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд нь улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлаггүй бөгөөд Төрийн мэдээллийн ХУР системээр дамжуулан шалгана. - Нийгмийн даатгал, Татварийн тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй, /Нийгмийн даатгал, Татварийн өргүй байх/ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) системээр дамжуулан системээр шалгана. <p>Тендерт оролцогч хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн тухай мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ.</p> |
| <p>ТШЗ 18.1</p> | <p>Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 он тус бүр гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсвийн 100 хувиас багагүй байх. - Түргэн хөрвөх хөрөнгөтэй холбогдох шаардлага Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. |
| <p>ТШЗ 18.2</p> | <p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - 2022 он болон 2023 оны санхүүгийн тайлан Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. |
| <p>ТШЗ 19.1</p> | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”.</p> <p>Цахилгааны инженер – 1</p> <p>Цахилгаанчин-1</p> <p>Хөдөлмөр, хамгааллын ажилтан - 1</p> <p>Жолооч -2 (Тусгай зориулалтын тээврийн хэрэгслийг ажиллуулах эрхтэй ажилтан)</p> <p>Хүний нөөцийн холбогдох диплом, сертификатыг ирүүлнэ.</p> <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Хүн өргөгч цамхагтай тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл-1 (өөрийн өмчлөл)</p> <p>Ачааны машин (5тн буюу түүнээс дээш даацтай) -1 (өөрийн өмчлөл)</p> <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”</p> <p>2022, 2023 онуудад гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын гэрээний үнийн дүнгийн нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн үнийн</p> |

| | |
|--|--|
| | <p><i>дүнгийн 50 хувиас багагүй байх бөгөөд ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ болон ажил хүлээлцсэн акт ирүүлнэ. Ижил төстэй ажилд гэрлэн дохионы засвар эсвэл гэрлэн дохио суурилуулсан ажил хамаарна.</i></p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> |
| ТШЗ 19.2 | <p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн гэрчилгээ</i> - <i>Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</i> - <i>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод байх шаардлагатай</i> |
| ТШЗ 19.3 | <p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана”</p> <p>Эрчим хүчний тусгай зөвшөөрөл</p> |
| ТШЗ 21.6 | <p>Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”</p> |
| ТШЗ 24.1 | <p>Тендерийн баталгааны дүн: 850,000 (Найман зуун тавин мянга) төгрөг</p> |
| Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ | |
| ТШЗ 25.5 | <p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>24.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> |
| ТШЗ 26.1 | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТШЗ 26.2 | <p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 10 минут</p> <p>Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 15, Нийслэлийн засаг захиргааны 4-р байр 7 давхар 705 тоот.</p> |
| Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ | |
| ТШЗ 31 | <p>Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: “Ашиглахгүй”</p> |

| | |
|--|--|
| ТШЗ 32.1 | Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй” |
| Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ | |
| ТШЗ 37.1 | Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. |
| Ё. БУСАД | |

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр**
Тендер шалгаруулалтын төрөл: Ажил
Тендер шалгаруулалтын нэр: **Гэрлэн дохио болон гадна талбайн бусад тоног төхөөрөмжүүдийн цахилгаан, тэжээл, худаг сувагчлал НХААГ/20240101287**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ/20240101287**

Нийт төсөвт өртөг: **170,000,000 (Нэг зуун далан сая) төгрөг**
Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **“Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минтаас** өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Тийм”**

Тендерийн баталгааний дүн: **850,000 (Найман зуун тавин мянга) төгрөг**

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Замын хөдөлгөөний удирдлагын төв, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 7 давхарт
705 тоот, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт хариуцсан
мэргэжилтэн Л.Мөнхжаргал

Холбоо барих утасны дугаар: 70111618